



Төлөөлөн удирдах зөвлөлийн
2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн
20 тоот Тогтоолын Хавсралт



**“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ
IC-17 V-2.0**

2022 он

Хамрах хүрээ: ИНВЕСКОР БЭСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ	Хариуцах эзэн: Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга
Хувийг хадгалах: ТУЗ-ийн дэргэдэх дэд хороод	Танилцах: ИНВЕСКОР БЭСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал
Хүчинтэй хугацаа: 2022 оны 06-р сарын 22-ны өдрөөс эхлэн	Хуудасны тоо. 14
Журмын дугаар: IC-17	Хувилбар: V- 2.0

Өөрчлөлтийн түүх

	Хувилбар	Өөрчлөлт хийгдсэн огноо	Өөрчлөлтийн агуулга
1.	V-2.0	2022.06.22	СЗХ-оос шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодекс”-д нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулав.
2.			
3.			
4.			
5.			

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны Журам (цаашид "Журам" гэх)-аар "Инвескор ББСБ" ХК (цаашид "Компани" гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн үндсэн чиг үүрэг, бүрэн эрх, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх этгээдэд тавигдах шаардлага, гишүүдийг сонгох Журам, дахин нэр дэвших болзол, хараат бус гишүүний шалгуур үзүүлэлт, ТУЗ-ийн хурлын зарыг хүргэх, хуралд оролцох, санал өгөх, ТУЗ-ийн гишүүдийг мэдээллээр хангах Журам, үүргээ зохих түвшинд хэрэгжүүлээгүй гишүүнд хүлээлгэх хариуцлага, бусад ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2 ТУЗ нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Компанийн тухай хууль, ББСБ-ын Дүрэм, Санхүүгийн Зохицуулах Хорооны баталсан Монголын Компанийн Засаглалын Кодекс болон бусад холбогдох эрх зүйн актыг мөрдөн ажиллана.
- 1.3 ББСБ-ын хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийн хүрээнд гарсан шийдвэр нь ТУЗ-ийн хувьд заавал биелэгдэх хүчинтэй байна.

2. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- 2.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт ББСБ-ын эрх барих байгууллага нь ТУЗ байна.
- 2.2 ТУЗ нь нийт 9 гишүүнтэй байх ба тэдгээрийн гурваас доошгүй нь хараат бус гишүүд байна.
- 2.3 ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд хүйсийн тэнцвэртэй байдлыг хадгалж, аль нэг хүйсийн эзлэх хувь гучаас доошгүй байхыг эрмэлзэнэ.
- 2.4 ТУЗ-ийн үйл ажиллагааны үндсэн зохион байгуулалтын хэлбэр нь хурал байна. Хурал нь ээлжит болон ээлжит бус гэсэн хэлбэртэй байна.
- 2.5 ТУЗ нь Хувьцаа эзэмшигчдийн өмнө жилд 1 удаа ажлаа тайлагнана.
- 2.6 ТУЗ нь өөрийн албан бичгийн хэвлэмэл хуудастай байж, ББСБ-ын тамга, тэмдгийг ашиглана.
- 2.7 ТУЗ-ийн гишүүн нь дээд боловсролтой, насанд хүрсэн, иргэний эрх зүйн бүрэн чадвар, чадамжтай, санхүү, бизнесийн зохих түвшний мэдлэгтэй, хууль тогтоомж, ББСБ-ын дүрмээр тогтоосон үүргийг бүрэн дүүрэн гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, боловсрол, дадлага, туршлагатай Монгол Улсын болон гадаад улсын иргэн байж болно. Хараат бус гишүүн нь энэ журмын 7 дугаар зүйлд заасан шалгууруудыг хангасан байна.
- 2.8 ТУЗ-ийн дарга нь ББСБ-ын Гүйцэтгэх захирлын албыг давхар хашихыг хориглоно.

3. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 ТУЗ нь дараах эрхтэй байна. Үүнд:
 - 3.1.1 ББСБ-ын эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг тогтоох, өөрчлөх;
 - 3.1.2 ББСБ-ын зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан Хувьцаа гаргах;
 - 3.1.3 ББСБ-ын дүрэмд заасан хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах;
 - 3.1.4 ББСБ-ын бүх төрлийн бодлогын баримт бичгийг батлах;
 - 3.1.5 ББСБ-ын Гүйцэтгэх захирлыг сонгох, түүний бүрэн эрхийг тогтоох, бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох, тусгайлсан асуудлаар түүнд итгэмжлэл олгох;
 - 3.1.6 Гүйцэтгэх Захиралтай байгуулах гэрээний нөхцөлийг батлах, өөрчлөлт оруулах, түүнд олгох, шагнал, урамшуулал, цалингийн хэмжээг тогтоох;
 - 3.1.7 Компанийн тухай хуулийн 55-р зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
 - 3.1.8 ББСБ-ын аудитын байгууллагыг сонгож, гэрээ байгуулах нөхцөлийг тогтоох;

- 3.1.9 ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо, Зээлийн хороо, Гүйцэтгэх захирлын зээл олгох, шийдвэрлэх хэмжээг тогтоох;
- 3.1.10 Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- 3.1.11 Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- 3.1.12 Ногдол ашиг хуваарилах эсэх талаар шийдвэр гаргаж, ногдол ашгийн хэмжээ, хуваарилах журам, бодлого тодорхойлох;
- 3.1.13 Хараат болон охин компани, салбар, төлөөлөгчийн газар байгуулах, тэдгээрийн эрх хэмжээ, үйл ажиллагааны чиглэлийг тогтоох;
- 3.1.15 ТУЗ-ийн дэргэдэх хороод байгуулах, тэдгээрийн гишүүдийг томилох, тэдгээрийн эрх, чиг үүргийг тодорхойлсон үйл ажиллагааны журмыг батлах;
- 3.1.16 ББСБ-ын дүрмээр болон хууль тогтоомжийн актад заасан бусад эрх;
- 3.1.17 ТУЗ нь дараах асуудлаар хөндлөнгийн мэргэжлийн этгээдийн зөвлөгөөг ББСБ-ын зардлаар авч болно. Үүнд:
 - а) ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүдийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх;
 - б) ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын нарийн бичгийн даргын ажлын гүйцэтгэлийг үнэлэх;
 - в) ТУЗ-ийн гишүүдийг анх томилогдох үеийн чиглүүлэх сургалт болон цаашид гишүүдийн мэдлэг, чадварыг дээшлүүлэхтэй холбоотой сургалтыг зохион байгуулах.
- 3.1.18 Хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал.
- 3.2 ТУЗ нь дараах үүрэгтэй байна. Үүнд:
 - 3.2.1 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
 - 3.2.2 Саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах, хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбоотой бусад асуудлыг шийдвэрлэх;
 - 3.2.3 ББСБ-ын стратеги болон дунд хугацаа, жилийн бизнес төлөвлөгөө, төсөв, үйл ажиллагааны бодлогыг батлах;
 - 3.2.4 ББСБ-ын бүтэц, зохион байгуулалт, орон тоог батлах;
 - 3.2.5 Компанийг өөрчлөн байгуулах төсөл боловсруулж Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх, шийдвэрийн төслийг бэлдэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
 - 3.2.6 ББСБ-ын жилийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэл, үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;
 - 3.2.7 ББСБ-ын Ёс зүйн дүрмүүд болон Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлогын хэрэгжилтэд хяналт тавих;
 - 3.2.8 Гүйцэтгэх захирлын шийдвэрлүүлэхээр оруулсан бусад асуудлыг шийдвэрлэх.
- 3.3 Журмын 3.1.7, 3.1.8, 3.1.9 болон 3.1.11 дэх заалтад заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд ТУЗ-ийн хараат бус гишүүд заавал оролцож саналаа өгнө.
- 3.4 Журмын 3.1 болон 3.2 дах хэсэгт заасан зарим ТУЗ-ийн бүрэн эрхийг тусгайлан ТУЗ-ийн дэргэдэх хороонд тэдгээрийн үйл ажиллагааны журмаар олгосон тохиолдолд тухайн хороо шийдвэр гаргана.

4. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

- 4.1 ТУЗ-ийн ээлжит хурлыг улиралд нэг удаа хуралдуулна.

- 4.2 ТУЗ-ийн ээлжит бус хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, Гүйцэтгэх захирал болон ББСБ-ын дүрэмд заасан бусад этгээдийн санаачилга, шаардлагаар хэдийд ч зарлан хуралдуулж болно.
- 4.3 ТУЗ-ийн гишүүд хуралд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд цахимаар зохион байгуулж болно. ТУЗ-ийн гишүүд биечлэн эсвэл цахимаар хуралдсанаас үл хамааран нийт гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно.
- 4.4 ТУЗ-ийн хурлыг цахимаар хуралдуулах тохиолдолд хурал болохоос хуанлийн 5 хоногийн өмнө ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн хурлыг цахимаар хуралдуулах тухай мэдээллийг ТУЗ-ийн гишүүдэд имэйлээр хүргүүлнэ.
- 4.5 ТУЗ-ийн хурлыг цахимаар хийх тохиолдолд хурлын дуу, дүрсний бичлэгийг хадгална.
- 4.6 ТУЗ-ийн гишүүд нь цахимаар хуралдахад хэлэлцэх асуудал бүр дээр санал өгөх бөгөөд цахимаар өгсөн санал нь ТУЗ-ийн хуралд биечлэн оролцсонтой адил хүчин төгөлдөр байна.
- 4.7 ТУЗ-ийн хурлыг цахимаар хуралдуулахад дараах зарчмыг баримтална. Үүнд:
- 4.7.1 Хуралд орлолцоход тохиромжтой дуу чимээгүй орчныг бүрдүүлсэн байх;
- 4.7.2 Интернет холболтыг сайтар шалгаж, камер, чихэвч, микрофоныг урьдчилан бэлтгэсэн байх;
- 4.7.3 Хуралд оролцохдоо ажил хэрэгч хувцаслаж, камераар дүрсээ дамжуулах;
- 4.7.4 Хэлэлцэх асуудлыг танилцуулах, асуулт асуух, хариулт өгөх, санал хэлэхээс бусад үед микрофоныг хаалттай байлгах.
- 4.8 ТУЗ-ийн хурлаар асуудал шийдвэрлэхэд ТУЗ-ийн гишүүн бүр саналын нэг эрхтэй байна. Цахимаар өгсөн санал нь ТУЗ-ийн хуралд биечлэн оролцсонтой адил хүчинтэй болно.
- 4.9 ТУЗ-ийн хуралд оролцсон гишүүдийн дийлэнхи олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.
- 4.10 ТУЗ-ийн гишүүдийн тоо нь тогтоосон нийт гишүүний тооноос 1 гишүүн байхгүй болсон тохиолдолд ББСБ нь 3 сарын дотор ТУЗ-ийн гишүүнийг сонгохоор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.
- 4.11 Компанийн тухай хууль болон ББСБ-ын дүрэмд заасны дагуу тухайн шийдвэрлэж байгаа асуудлаар ТУЗ-ийн зарим гишүүн санал өгөх эрхгүй байвал шийдвэрийг саналын эрхтэй ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 4.12 ТУЗ-ийн хурлын хэлэлцэх асуудалд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд хурал хуралдахаас хуанлийн 14 хоногийн дотор ТУЗ-ийн гишүүд нэмэлт өөрчлөлтийн саналаа ТУЗ-ийн Нарийн бичгийн даргад хүргүүлж болно. Ийнхүү асуудал оруулах саналд дараах зүйлсийг тусгана. Үүнд:
- 4.12.1 Санал оруулж буй этгээд, түүний мэдээлэл;
- 4.12.2 ТУЗ-ийн хэлэлцэх асуудалд нэмж оруулахаар санал болгож буй асуудлын томъёолол;
- 4.12.3 Асуудал оруулах шалтгаан;
- 4.12.4 Асуудлыг хэлэлцэхээр санал болгож буй хугацаа;
- 4.12.5 Санал оруулж буй этгээдийн нэр, гарын үсэг.
- 4.13 Батлагдсан ажлын төлөвлөгөөнд асуудал нэмж оруулах, хасах, тэдгээрийн томъёоллыг өөрчлөх саналыг ТУЗ эчнээ санал хураалтаар шийдвэрлэж болно.
- 4.14 ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн хурлын мэдэгдлийг хурал хуралдах өдрөөс ажлын 5 хоногийн өмнө ТУЗ-ийн гишүүдэд цахим шуудангаар хүргүүлнэ.

- 4.15 Мэдэгдэлд хурлаар хэлэлцэх асуудал, хурал хуралдах өдөр, цаг, газар, хуралд уригдсан этгээдийн жагсаалтыг тусгана. Үүнд:
 - 4.15.1 Хэлэлцэх асуудлаарх ТУЗ-ийн шийдвэрийн төсөл;
 - 4.15.2 Холбогдох баримт, мэдээлэл;
 - 4.15.3 Эчнээ санал хураалт явуулах тохиолдолд саналын хуудас.
- 4.16 ТУЗ нь хаалттай хуралдах тохиолдолд хурлын материалыг бэлтгэх, хурлын тэмдэглэл, тогтоолыг боловсруулахад ББСБ-ын нууцын бодлого, журам, шаардлагыг мөрдөнө.
- 4.17 ТУЗ-ийн ээлжит бус хурал зарлан хуралдуулах тухай хүсэлтэд дараах зүйлсийг тусгана. Үүнд:
 - 4.17.1 Хуралдуулах хүсэлт гаргасан этгээд, түүний мэдээлэл;
 - 4.17.2 Хэлэлцэх асуудлын томъёолол;
 - 4.17.3 Асуудлыг хэлэлцүүлэх шалтгаан;
 - 4.17.4 Асуудлыг хэлэлцүүлэхэд шаардлагатай баримт материал;
 - 4.17.5 Шаардлагатай тохиолдолд хурал хуралдах өдрийг заах, хурлаас гарах шийдвэрийн төсөл;
- 4.18 ТУЗ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тов бүхий шаардлагыг ийнхүү хурал хуралдуулахаар санал болгож буй өдрөөс хуанлийн 14-өөс доошгүй хоногийн өмнө ТУЗ-ийн Нарийн бичгийн даргад хүргүүлнэ.
- 4.19 ТУЗ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш хуанлийн 5 хоногийн дотор ТУЗ-ийн дарга шийдвэрлэнэ.
- 4.20 ТУЗ-ийн дарга дор дурдсанаас бусад тохиолдолд ТУЗ-ийн хурлыг зарлан хуралдуулахаас татгалзах эрхгүй:
 - 4.20.1 Хурал зарлан хуралдуулах шаардлага нь хууль тогтоомжид нийцэхгүй байх;
 - 4.20.2 Хэлэлцүүлэхээр оруулсан асуудал нь ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарахгүй байх;
 - 4.20.3 Шаардлага гаргагч нь хурал зарлан хуралдуулах эрх хэмжээгүй байх.
- 4.21 ТУЗ-ийн хурлыг эчнээ санал хураалтаар явуулах тохиолдолд хурлын мэдэгдлийг саналын хуудасны хамтаар хурал хуралдахаас хуанлийн 5 хоногийн өмнө хүргүүлнэ.
- 4.22 Саналын хуудсанд дараах зүйлийг тусгана. Үүнд:
 - 4.22.1 Эчнээ санал хураалтаар хурал хуралдуулах тухай үндэслэл, шаардлага, мэдээлэл;
 - 4.22.2 Хэлэлцэх асуудал;
 - 4.22.3 Хэлэлцэх асуудал бүрээр гаргах шийдвэрийн төсөл;
 - 4.22.4 Санал хураалтын саналууд ("зөвшөөрсөн", "татгалзсан", "түдгэлзсэн");
 - 4.22.5 Санал хураалтын холбогдох саналыг бөглөх арга (доогуур зурах, дарах);
 - 4.22.6 Саналын хуудсанд ТУЗ-ийн гишүүнээр гарын үсэг зуруулах заалт;
 - 4.22.7 Бөглөсөн саналын хуудсыг ТУЗ-ийн Даргад хүргүүлэх огноо, хэлбэр.
- 4.23 ТУЗ-ийн гишүүдээс хүлээн авсан саналын хуудсыг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга хүлээн авч, ТУЗ-ийн даргын даалгаснаар нэгтгэн боловсруулах ажлыг гүйцэтгэнэ.
- 4.24 ТУЗ-ийн гишүүд эчнээ санал хураалтын мэдэгдэл болон саналын хуудсыг хүлээж авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан саналаа ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар дамжуулан ТУЗ-ийн даргад хүргүүлнэ.
- 4.25 ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга хөтөлнө. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд дараах зүйлсийг тусгана. Үүнд:
 - 4.25.1 Хурал хуралдсан газар, өдөр, цаг;
 - 4.25.2 Хуралд оролцсон гишүүд;
 - 4.25.3 Хурлаар хэлэлцсэн асуудал;

- 4.25.4 Санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал болон санал хураалтын дүн;
4.25.5 Гаргасан шийдвэр.
- 4.26 ТУЗ-ийн хурлын явцад дууны эсхүл дуу, дүрсний бичлэг хийх ба ТУЗ-ийн нарийн бичгийн дарга архивлаж хадгална.
- 4.27 ТУЗ-ийн хурлаас тогтоол гарах бөгөөд түүнд ТУЗ-ийн хурлын дарга гарын үсэг зурж, ББСБ-ын тамга дарагдсанаар хүчин төгөлдөр болно.
- 4.28 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг хурал хуралдсанаас хойш ажлын 5 хоногийн дотор бичгийн хэлбэрт буулгах бөгөөд хуралд оролцсон гишүүдэд танилцуулахаар хүргүүлнэ.
- 4.29 ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүд гарын үсэг зурах бөгөөд тухайн тэмдэглэлийн үнэн зөвийг хурлын дарга хариуцна.
- 4.30 ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг буруу хөтөлсөн нь тухайн хурлаас гаргасан шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.

5. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙГ ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ

- 5.1. ТУЗ-ийн гишүүдийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 3 жилийн хугацаатай сонгоно.
- 5.2. ТУЗ-ийн гишүүнийг хэдэн ч удаа улируулан сонгож болно. ТУЗ-ийн гишүүнийг улируулан сонгох асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхдээ гишүүнээр ажилласан нийт хугацаа, өмнөх бүрэн эрхийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, ТУЗ-ийн гишүүний үнэлгээ зэрэг мэдээллийг танилцуулна.
- 5.3. ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдахаас өмнө ТУЗ-ийн гишүүнийг улируулан сонгохтой холбоотой дээрх 5.2-т заасан бичиг баримтуудыг эрх бүхий этгээдээс гаргуулан авч, Хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр танилцуулна.
- 5.4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгох саналыг тус тусад нь тоолно. ТУЗ-ийн гишүүнийг сонгохдоо санал хураах ердийн аргыг хэрэглэнэ.
- 5.5. Энэ Журмын 5.4-т заасан саналаа Хувьцаа эзэмшигч нь ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд эзлэх хувьд хуваагдсан хэмжээнд бүгдийг нь нэг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчид, эсхүл хэд хэдэн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.
- 5.6. ТУЗ-ийн гишүүн нь ББСБ-ын эрх ашигт нийцүүлэн үйл ажиллагаа явуулах ба сонирхлын зөрчилтэй бол сайн дураараа эсхүл ТУЗ-ийн гишүүний шийдвэрээр ТУЗ-ийн бүрэн эрхийг түдгэлзүүлнэ.
- 5.7. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрх дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:
- 5.7.1. Өөрөө хүсэлт гаргасан;
 - 5.7.2. Бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадваргүй болсон;
 - 5.7.3. ТУЗ-ийн гишүүний ажил үүргийг хэрэгжүүлэх боломжгүй албан тушаалд томилогдсон;
 - 5.7.4. ТУЗ-ийн гишүүд хууль тогтоомж зөрчсөн, захиргааны зөрчил болон эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогдсон, бизнес, санхүү, татвар, үнэт цаасны чиглэлээр зөрчил дутагдал гаргасан бол;
 - 5.7.5. Хуульд заасан бусад нөхцөл байдал.
- 5.8. ТУЗ-ийн гишүүн удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан тохиолдолд ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлж, энэ

Журамд заасан шаардлага хангасан орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл ТУЗ түр томилно.

- 5.9. Энэ Журмын 5.9-д заасны дагуу томилогдсон этгээд нь хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг хангасан байх ба ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг эдэлнэ.
- 5.10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрээр ТУЗ-ийн бүрэн эрхийг, гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно.

6. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН

- 6.1. ТУЗ-ийн гишүүн нь дараах эрхтэй байна. Үүнд:
 - 6.1.1. ТУЗ-ийн дэргэдэх хороодод харьяалагдан ажиллах;
 - 6.1.2. ТУЗ-ийн дарга, хорооны дарга зэрэг бусад сонгуульд албан тушаалд сонгогдох, тэдгээрт өөрийн нэрийг дэвшүүлэх;
 - 6.1.3. ББСБ-ын дүрэм, Журам, бүртгэл, тайлан, санхүүгийн болон аудитын байгууллагын дүгнэлт болон ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах бусад холбогдох баримт материалтай ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар дамжуулан танилцах;
 - 6.1.4. ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар дамжуулан хурлаар хэлэлцэж байгаа асуудлын талаар асуулт тавьж, хариулт авах, санал дүгнэлт гаргах, санал тавих;
 - 6.1.5. ТУЗ-ийн шийдвэрийн биелэлтийн талаар холбогдох албан тушаалтнаас ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар дамжуулан мэдээлэл шаардаж авах.
- 6.2. ТУЗ-ийн гишүүн нь дараах үүрэгтэй байна. Үүнд:
 - 6.2.1. Үйл ажиллагаандаа ББСБ-ын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлах, ББСБ-ын нэрийг хувийн сонирхлоор ашиглахгүй байх;
 - 6.2.2. Албан үүргээ хэрэгжүүлэхдээ олж авсан ББСБ-ын болон бизнесийн нууцад хамаарах аливаа мэдээллийг албан тушаалаасаа чөлөөлөгдсөнөөсөө хойш 3 жилийн хугацаанд задруулахгүй байх, дамжуулахгүй байх, хувийн зорилгоор ашиглахгүй байх;
 - 6.2.3. ББСБ-ын эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах бөгөөд шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ тухайгаа тухай бүр мэдэгдэх;
 - 6.2.4. Хувьцаа эзэмшигчид үнэн зөв мэдээлэл өгөх;
 - 6.2.5. Өвчтэй, чөлөөтэй байх, гадаад, дотоодод томилолтоор ажиллахаас бусад тохиолдолд ТУЗ-ийн болон хороодын хуралдаанд товлосон хугацаанд хүрэлцэн ирж оролцох;
 - 6.2.6. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ТУЗ-ийн болон хороодын хуралдаанд биечлэн оролцох боломжгүй бол энэ тухайгаа ТУЗ-ийн Нарийн бичгийн даргад урьдчилан мэдэгдэх;
 - 6.2.7. ТУЗ-ийн хурлын дэгийг сахиж ажиллах;
 - 6.2.8. Хууль тогтоомж, гишүүний ёс зүйг чанд сахих, өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хөндлөнгийн этгээдээс бэлэг, урамшуулал авахгүй байх;
 - 6.2.9. Өөрийн болон нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх мэдээлэл, тэдгээрийн өөрчлөлтийг тухай бүр ТУЗ-ийн Нарийн бичгийн даргад загварын дагуу гаргаж өгөх;
 - 6.2.10. ТУЗ-ийн гишүүн нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.
 - 6.2.11. ТУЗ-ийн гишүүн нь анх томилогдсоныхоо дараа чиглүүлэх сургалтад, цаашлаад өөрийн ажил үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох сургалтад тогтмол хамрагдана.

- 6.3. ТУЗ-ийн хараат бус гишүүнд дараах шалгуурыг хангасан этгээдийн нэрийг дэвшүүлнэ. Үүнд:
- 6.3.1. Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран ББСБ-ын энгийн Хувьцааны 5 (тав)-аас дээш хувийг эзэмшдэггүй;
 - 6.3.2. Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь ББСБ болон ББСБ оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид эрх бүхий албан тушаал эрхэлдэггүй;
 - 6.3.3. Төрийн үйлчилгээнээс бусад төрийн алба хашдаггүй;
 - 6.3.4. ББСБ-тай бизнесийн аливаа холбоогүй.
- 6.4. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь бусад гишүүний адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах нэмэлт үүргийг хүлээнэ. Үүнд:
- 6.4.1. ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь тухайн ББСБ-ын эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавих, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илэрвэл уг зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах, шаардлагыг эс биелүүлбэл уг асуудлыг ТУЗ-д тавьж шийдвэрлүүлэх, улмаар Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх;
 - 6.4.2. ББСБ-ын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар Гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;
 - 6.4.3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, ТУЗ-ийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, Хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх.

7. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

- 7.1. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн дотроос нийт гишүүний дийлэнх олонхийн саналаар сонгоно.
- 7.2. ТУЗ-ийн даргын бүрэн эрхийн хугацаа нь ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаагаар тодорхойлно. ТУЗ-ийн гишүүн нь ТУЗ-ийн даргаар хэдэн ч удаа сонгогдож болно.
- 7.3. ТУЗ-ийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.
- 7.4. ТУЗ-ийн даргын түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын, эсхүл ТУЗ-ийн томилсон гишүүн гүйцэтгэнэ.
- 7.5. ТУЗ-ийн дарга нь дараах эрхтэй байна. Үүнд:
 - 7.5.1. ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлын дарааллыг өөрчлөх, шаардлагатай тохиолдолд хэлэлцэх асуудлыг бүхэлд нь өөрчлөх, шинээр асуудал нэмж хэлэлцүүлэх;
 - 7.5.2. ТУЗ-ийн хурлын тэмдэглэл хөтлүүлэх, түүнд хяналт тавих, гарын үсэг зурах;
 - 7.5.3. ТУЗ-ийн нэрийн өмнөөс ББСБ-ын удирдлага, бусад байгууллагатай харилцаж, Хувьцаа эзэмшигчдийн шийдвэрийн гүйцэтгэлийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;
 - 7.5.4. ББСБ-ын нэрийн өмнөөс Гүйцэтгэх захиралтай хөдөлмөрийн гэрээ байгуулах.
- 7.6. ТУЗ-ийн дарга нь дараах үүрэгтэй байна. Үүнд:
 - 7.6.1. ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулах;
 - 7.6.2. ТУЗ-ийн хурлыг зарлан хуралдуулж, хурлыг даргалах;
 - 7.6.3. ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлыг хурал хуралдахаас өмнө баталж, ТУЗ-ийн гишүүдэд мэдээлэх, ББСБ-ын дүрэм болон энэхүү Журамд заасны дагуу хурлын ирц, шийдвэр хүчин төгөлдөр тооцогдох эсэхийг мэдээлэх;

- 7.6.4. ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын үйл ажиллагааг хянах;
- 7.6.5. Эцнээ санал хураалтын ажиллагааг зохион байгуулах;
- 7.6.6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит, ээлжит бус хурлын бэлтгэл явцыг хянах;
- 7.6.7. ТУЗ-ийн дотоод үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах;
- 7.6.8. ТУЗ-ийн шийдвэрийг тайлбарлаж, ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар ТУЗ-ийн байр суурийг илэрхийлэх, мэдээлэх;
- 7.6.9. ББСБ-ын Дүрэм, энэхүү Журамд заасан шаардлагыг ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих.
- 7.7. ТУЗ-ийн даргын бүрэн эрх дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:
 - 7.7.1. Өөрөө хүсэлт гаргасан;
 - 7.7.2. Бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадваргүй болсон;
 - 7.7.3. Хуулиар тодорхойлогдсон бусад тохиолдолд.
- 7.8. ТУЗ-ийн даргын бүрэн эрх дуусгавар болсноос хойш 14 хоногийн дотор энэ Журмын 7.1 - д заасны дагуу ТУЗ-ийн даргыг сонгоно.

8. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

- 8.1 ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг болон түүний эзгүйд орлох этгээдийг томилно.
- 8.2 ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын бүрэн эрхийн хугацаа нь ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаа байна. ТУЗ-ийн Нарийн бичгийн даргыг томилсон шийдвэрт түүний бүрэн эрхийн хугацааг өөрөөр зааж болно.
- 8.3 ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.
- 8.4 ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын эрх үүргийг ТУЗ-аас баталсан журмын дагуу зохицуулна.
- 8.5 ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь дараах эрхтэй байна. Үүнд:
 - 8.5.1 Өөрийн үүргийг гүйцэтгэхтэй холбоотойгоор ББСБ-ын газар, алба болон албан тушаалтнаас мэдээлэл авах;
 - 8.5.2 Компанийн засаглалыг сайжруулахтай холбоотой өөрийн санал, хүсэлтийг ТУЗ болон бусад эрх бүхий албан тушаалтанд гаргах;
- 8.6 ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь дараах үүрэгтэй байна. Үүнд:
 - 8.6.1 ТУЗ-ийн бичиг хэргийг хариуцан хөтлөх, ТУЗ-ийн гишүүдэд мэдээлэл хүргэх;
 - 8.6.2 ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодод засаглалын асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх;
 - 8.6.3 ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын бодлогын баримт бичиг, дотоод журмын хэрэгжилтэд хяналт тавих;
 - 8.6.4 ТУЗ-ийн гишүүдийн сургалтыг зохион байгуулах;
 - 8.6.2 ТУЗ-ийн хурлын бэлтгэлийг хангах, хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл болон гарах шийдвэрийн төсөл, бусад баримт бичгийг зохих журмын дагуу бэлтгэх, хүргэх ажлыг зохион байгуулах;
 - 8.6.3 ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг хөтлөх, гарах шийдвэрийг зохих журмын дагуу баталгаажуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих;
 - 8.6.4 Шинээр томилогдож буй ТУЗ-ийн гишүүн бүрд цалин урамшуулал, хариуцлагын даатгал, хараат бус гишүүний хувьд хараат бус байдал алдагдал нөхцөл байдал

- үүссэн тохиолдолд мэдэгдэх болон ББСБ-ын мэдээлэлтэй харьцах дэг журам, нууцлалын үүрэг, ББСБ-ын дотоод бодлого, журам зэргийг бичгээр танилцуулж, гарын үсэг зуруулан баталгаажуулах;
- 8.6.5 Компанийн тухай хуулийн 97.1-д заасан дараах баримт бичгийг хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах, архивд шилжүүлнэ. Үүнд:
- а) ББСБ-ын дүрэм, түүнд орсон нэмэлт, өөрчлөлт, Компанийг байгуулах тухай үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэр;
 - б) Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ болон ТУЗ-ийн хороодын шийдвэр, хурлын тэмдэглэл;
 - в) ББСБ-ын салбар болон төлөөлөгчийн газрын дүрэм;
 - г) Хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулан хувьцаа эзэмшигчид тараасан баримт бичиг болон хувьцаа эзэмшигчээс хурлын хэлэлцэх асуудалд оруулахаар ирүүлсэн санал;
 - д) ББСБ-ын санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан (хуулбар хувийг);
 - е) Хувьцаа болон үнэт цаас гаргах Журам (хуулбар хувийг);
 - ё) ББСБ-ын нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалт болон тэдгээрийн эзэмшлийн хувьцааны төрөл, тоо;
 - ж) ББСБ-ын санхүүгийн тайлангийн талаарх аудитын дүгнэлт (хуулбар хувийг);
 - з) ББСБ-ын эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалт;
 - и) ББСБ-ын 5 (тав)-аас дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа этгээдийн нэрсийн жагсаалт, тэдгээрийн эзэмшлийн хувьцааны тоо.
- 8.6.6 Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, Гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах ажлыг зохион байгуулах;
- 8.6.7 ТУЗ-ийн дотоод үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах;
- 8.7 ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь ББСБ-ын ажилтан, зээлдүүлэгч, харилцагч, ханган нийлүүлэгчидтэй харилцааг ажиллагааг зохион байгуулна.
- 8.8 ББСБ-ын ажилтан, зээлдүүлэгч, харилцагч, ханган нийлүүлэгч нь ТУЗ-ийн Нарийн бичгийн даргад санал, хүсэлт, гомдол гаргах тохиолдолд enerekl@invescore.mn хаягаар болон ББСБ-ын цахим хуудсаар дамжуулан илгээнэ.
- 8.9 ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь ББСБ-ын ажилтан, зээлдүүлэгч, харилцагч, ханган нийлүүлэгчээс ирсэн санал, хүсэлт, гомдлыг дараах байдлаар шийдвэрлэж, хариу өгнө. Үүнд:
- 8.9.1 Өөрийн эрх хэмжээнд шийдвэрлэх асуудал бол өөрөө
 - 8.9.1 Өөрийн эрх хэмжээнд хамаарахгүй асуудал байх тохиолдолд ТУЗ эсвэл ТУЗ-ийн дэргэдэх хороодод хүргүүлэн шийдвэрлүүлэх
- 8.10 ББСБ-ын ажилтан, зээлдүүлэгч, харилцагч, ханган нийлүүлэгч нь ТУЗ-тай зөвхөн ТУЗ-ийн Нарийн бичгийн даргаар дамжуулан харилцана.

9. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

- 9.1 ТУЗ нь дэргэдээ тухайлсан чиг үүрэг, эрхийг хэрэгжүүлэх зорилго бүхий хороодыг байгуулж болно.
- 9.2 ТУЗ-ийн дэргэд түүний гишүүдээс бүрдсэн Аудитын, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын, Эрсдэлийн удирдлагын хороод ажиллана.

- 9.3 Компанийн сайн засаглалыг хөгжүүлэх үүднээс ТУЗ-ийн шийдвэрээр шинээр хороог үүсгэн байгуулж болно.
- 9.4 ТУЗ-ийн дэргэдэх хороод тус бүр нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.
- 9.5 Хороодын гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаагаар тодорхойлогдоно.
- 9.6 Хороод чиг үүргийн дагуу өөрсдийн холбогдох үйл ажиллагааны Журамд заасны дагуу хуралдаж, хэлэлцсэн асуудлаар санал, дүгнэлт боловсруулан ТУЗ-д танилцуулна.
- 9.7 Хороо нь тусгайлан олгогдсон эрхийнхээ дагуу шийдвэр гаргана.
- 9.8 Хороодын ажиллах нөхцөлийг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга хангаж ажиллана.
- 9.9 ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны журмыг ТУЗ баталж, мөрдүүлнэ.
- 9.10 Хороодыг байгуулах тохиолдолд хороодын ажиллах зарчим, хорооны гишүүдэд тавигдах шаардлага, эрх хэмжээг тусгайлсан хороодын үйл ажиллагааны журмаар зохицуулна.

10. ИХ ХЭМЖЭЭНИЙ БА СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

- 10.1. ББСБ нь Компанийн тухай хууль болон Дүрэмд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах тохиолдолд хэлцэл хийхээс өмнө ТУЗ-д танилцуулах бөгөөд ТУЗ нь хэлцэл хийх зөвшөөрөл олгоно.
- 10.2. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх саналыг ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороогоор хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулсны дараа ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлнэ.
- 10.3. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж, зөвшөөрөл олгосон их хэмжээний хэлцлийн бүртгэлийг энэхүү журмын Хавсралт №2, сонирхлын зөрчилтэй хэлцлийг энэхүү журмын Хавсралт №3-т заасан маягтын тус тус бүртгэж, хөтөлнө.
- 10.4. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн бүртгэлд ТУЗ-ийн дарга хяналт тавина.
- 10.5. ББСБ санхүүгийн тайлангийн хугацаанд хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн тоо, хэлцэл хийсэн этгээд, хэлцлийн үнийн талаарх мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд тусгана.
- 10.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь сонирхлын зөрчилтэй хэлцлийн бүртгэлийг улирал бүр ББСБ-ын үйл ажиллагааны тайлан гаргах чиг үүрэг бүхий албан тушаалтанд илгээнэ.

11. ХАРИУЦЛАГА

- 11.1. ТУЗ-ийн гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 3 болон түүнээс дээш удаа хуралд дараалан оролцоогүй тохиолдолд ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөх асуудлыг хэлэлцэж болно.
- 11.2. ТУЗ-ийн гишүүн нь энэхүү Журмын дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу түүний буруутай үйл ажиллагааны улмаас Компанид хохирол учирвал учирсан хохирлыг буруутай этгээдээр хувийн эд хөрөнгөнөөс бүрэн хэмжээгээр нөхөн төлүүлнэ.
- 11.3. ТУЗ-ийн гишүүн нь гэмт хэрэг үйлдсэний улмаас Компанид хохирол учирсан тохиолдолд шүүхэд хандан учирсан хохирлоо шаардах эрхтэй байна.
- 11.4. ТУЗ-ийн гишүүн, ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь дараах хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас Компани, хувьцаа эзэмшигчид учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө. Үүнд:
 - 11.4.1. ББСБ-ын нэрийг хувийн сонирхлоор ашигласан;
 - 11.4.2. Хувьцаа эзэмшигчид санаатайгаар худал мэдээлэл өгсөн;
 - 11.4.3. Мэдээлэл өгөх үүргээ биелүүлээгүй;
 - 11.4.4. Энэхүү Журмын 8.6.5-д баримт бичгүүдийг зохих журмын дагуу хадгалаагүй;

11.4.5. Компанийн тухай хуулийн 98 дугаар зүйлд заасан мэдээллийг мэдээлэл авах эрх бүхий этгээдэд гаргаж өгөөгүй эсвэл хугацаа хожимдуулан гаргаж өгсөн.

12. БУСАД

- 12.1. Журам нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 12.2. Журамд нэмэлт өөрчлөлт оруулах эрхийг ТУЗ эдлэх бөгөөд тухайн нэмэлт өөрчлөлтийг баталснаар энэхүү журмын адил хүчин төгөлдөр болно.

—ooOoo—

НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДИЙГ БҮРТГЭХ ХУУДАС

1. ББСБ-тай дараах хамааралтай этгээдийг “НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭД”-д тооцож бүртгэнэ. Үүнд:
 - 1.1. Тодорхой гэрээний үндсэн дээр хамтран тухайн компанийн удирдлагын шийдвэрийг тодорхойлох боломж бүхий бүлэг хүмүүс;
 - 1.2. Компанийн нэгдэлд хамаарч байгаа компанийн хувьд компанийн нэгдлийн бусад оролцогч компани, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан;
 - 1.3. Компанийн удирдлагын шийдвэрийг хамтран тодорхойлох боломж бүхий компани болон хүн (бүлэг хүмүүс);
 - 1.4. Нэг хүн (бүлэг хүн) гаргах шийдвэрийг нь тодорхойлох боломж бүхий компани;
 - 1.5. Компани болон уг компанийн эрх бүхий албан тушаалтан;
 - 1.6. Нэг гэр бүлийн гишүүн, эцэг, эх, хүүхэд, ач, зээ нар ах дүү, бусад төрөл, садны хүн;
 - 1.7. Нэг хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид;
 - 1.8. Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь хувьцааны хяналтын багцыг нь эзэмшдэг болон эрх бүхий албан тушаалд ажилладаг компани, уг компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогч компани болон тэдгээрийн хувьцааны хяналтын багцыг эзэмшигч болон эрх бүхий албан тушаалтан;
 - 1.9. Уг этгээд ажил олгогч бол түүний ажилтан.

№	Нэр	Нэгдмэл сонирхолтойд тооцогдох хамаарал (хуулийн үндэслэл)	Хувьцааны хамаарал		
			Төрөл	Тоо	Эзэмшил хувь
1					
2					
3					
4					

2. Нэгдмэл сонирхолтой этгээд нь нэгдмэл сонирхолтой этгээдэд тооцогдох хамаарал нэмэгдсэн, өөрчлөгдсөн тохиолдолд тус үйл баримтын талаар ББСБ-д ажлын 3 (гурв) хоногийн дотор мэдэгдэнэ.

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ БҮРТГЭХ ХУУДАС

1. ББСБ-ын хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол “СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ”-д тооцож бүртгэнэ. Үүнд:

- Хэлцлийн нөгөө тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа
- Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20-оос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
- Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
- Хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа.

№	Хэлцлийн мэдээлэл				Сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох хуулийн үндэслэл
	Хэлцлийн нөгөө тал	Хэлцлийн нэр	Огноо	Хэлцлийн дүн	
1					
2					
3					
4					

2. ТУЗ-ийн хурлын сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосон тогтоол, шийдвэрийн эх хувийг энэхүү бүртгэлийн хавсралтаар хадгална.

ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ БҮРТГЭХ ХУУДАС

1. Компанийн “ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ”-д дараах хэлцлийг тооцож бүртгэнэ.
Үүнд:

- Хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл ;
- компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт.

№	Хэлцлийн мэдээлэл				Нэг удаагийн эсхүл холбоотой хэд хэдэн хэлцэл эсэх тэмдэглэл
	Хэлцлийн нэр	Огноо	Хэлцлийн дүн	Активын нийт дүнгийн 25 хувь	

2. Компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцлийн дүн их хэмжээний хэлцэлд хамаарахгүй тул бүртгэхгүй.
3. ТУЗ-ийн хурлын их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгосон тогтоол, шийдвэрийн эх хувийг энэхүү бүртгэлийн хавсралтаар хадгална.